



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/120/СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Дорноговь аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ .....</b>	<b>3</b>
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2020.02.21 № 1-6/101  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД  
СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН  
ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Ю.ЧУЛУУНБААТАР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Ю.Чулуунбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-аас 2020 оны 02 дугаар сарын 04-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 35<sup>10</sup>/4130 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь найдвартай, баталгаатай үйлчилгээ, иргэд олон нийтийн итгэл дэмжлэгт оршино.

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “aculous” программ хангамж ашигладаг байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 498,253.1 мянган төгрөгөөс тооцон 4,982.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,253.8 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,806.9 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	584.9	1,999.3	1,414.4
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	94,063.3	86,016.3	-8,047.0
Үндсэн хөрөнгө	1,269,833.0	1,249,658.6	-20,174.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,364,481.2</b>	<b>1,337,674.2</b>	<b>-26,807.0</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,364,481.2	1,337,674.2	-26,807.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,364,481.2</b>	<b>1,337,674.2</b>	<b>-26,807.0</b>

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тухайн албанд ажиллаж байгаад цалин бодож олгосны дараа шилжиж явсан алба хаагчаас авах авлага 291.9 мянган төгрөг, амралтын цалин урьдчилж олгоод цалин бодохдоо суутгал тал дээр суутгаж аваагүй 931.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын авлага 11.8 мянган төгрөг, ХХОАТ-ын авлага 524.7 мянган төгрөгөөс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2017, 2018, 2019 онуудад үүссэн 239.6 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна. Үүнээс баримтын шалгалтаар тэтгэвэрт гарсан алба хаагчдын томилолт илүү олгосон байсан ба тухайн алба хаагчид нь тус хэлтэст ажиллахгүй байгаа шалтгааны улмаас барагдах боломжгүй байна. Нийт 1,999.4 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь нийт бараа материалын зарцуулалттай холбоотой буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдийг данснаас хасч Орон нутгийн өмчийн газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу дахин үнэлж авсан. Салбар хоорондын тооцоогоор 32,209.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө 45.0 мянган төгрөгөөр буурсан байна. Бие бус хөрөнгө нь 150.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй байсан ба элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дууссан учир дахин үнэлэн нийт 105.0 мянган төгрөгөөр орлогод авсан байна.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 26,806.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн тайлант онд 10,300.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 10,324.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	10,300.0	10,324.4	-24.4	100
<b>Нийт дүн</b>	10,300.0	10,324.4	-24.4	100

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр 3 зориулалтад 901,472.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 899,751.5 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 1,325.0 мянган төгрөгийг бусад урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 891,172.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 10,300.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 901,076.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 753,562.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 16,213.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 47,801.0 мянган төгрөг, хангамж бараа материал 39,862.2 мянган төгрөг, нормативт зардал 13,370.8 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 21,132.8 мянган төгрөг, томилолт зочны зардал 6,291.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 656.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 860.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 1,325.0 мянган төгрөг/ нийт дүнгээр 485.5 мянган төгрөг хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хууль зүй дотоод хэргийн яамнаас 2,340.0 мянган төгрөг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 800.0 мянган төгрөг, Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 606.8 мянган төгрөг, Замын-Үүд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 405.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,955.1 мянган төгрөг, нийт 6,106.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Тээвэр шатахуунд 40.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн эдлэгдэх зүйлсэд 265.5 мянган төгрөг, хоол хүнсэнд 139.5 мянган төгрөг, урсгал засварт 2,809.5 мянган төгрөг, дотоод албан томилолтод 118.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 2,733.5 мянган төгрөг, нийт 6,106.9 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,373.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,144.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 229.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 229.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1 Зардлын данстай холбоотой асуудал

#### 1.1 Илрүүлэлт:

*Үндсэн цалингийн зардлаас 229.1 мянган төгрөгийн гэрэл цахилгааны төлбөрийг төлсөн.*

*Энэ нь (үнэн зөв, иж бүрэн байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын үндсэн цалингийн зардал “цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.*

#### 1.2 Эрсдэл:

*Зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй хяналт сул байгаагаас үргүй зардал гарах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.*

#### 1.3 Өгсөн зөвлөмж:

*Үндсэн цалингийн зардлаас журамд зааснаас бусад зардлыг гаргахгүй байх.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>94,648,212.99</b>	<b>88,015,652.16</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	584,939.52	1,999,394.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	417,398.52	1,999,394.26
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	167,541.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	167,541.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	94,063,273.47	86,016,257.90
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	36,317,255.65	42,721,652.85
35110	Тусгай зориулалттай материал	35,599,065.65	42,027,956.95
35130	Эм боох материал	718,190.00	693,695.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	53,436,017.82	39,473,999.05
35410	Бичиг хэргийн материал	10,666,228.26	10,655,384.00
35420	Аж ахуйн материал	7,819,922.40	7,795,183.89
35430	Сэлбэг хэрэгсэл	3,328,400.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	2,657,796.66	395,456.66
35450	Барилгын засварын материал	16,133,615.00	3,481,775.00
35460	Хүнсний материал	85,388.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	12,744,667.50	17,146,199.50
35600	Мал амьтад	4,310,000.00	3,820,606.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,269,833,013.22</b>	<b>1,249,658,641.48</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,269,833,013.22	1,249,658,641.48
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,122,686,179.76	1,102,427,641.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	958,145,052.98	958,145,052.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-39,088,306.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	199,901,875.04	178,080,455.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	-112,057,055.96	-98,576,022.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	168,796,645.93	179,751,314.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,927,824.84	-87,030,961.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,865,296.39	22,184,460.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,630,692.07	-14,355,621.19
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3,083,951.00	3,083,951.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,995,000.00	2,995,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,486,068.71	-2,761,678.71
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	147,146,833.46	147,231,000.00
39301	Програм хангамж	150,000.00	105,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-129,166.54	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	147,126,000.00	147,126,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,364,481,226.21</b>	<b>1,337,674,293.64</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,364,481,226.21</b>	<b>1,337,674,293.64</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,364,481,226.21	1,337,674,293.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	450,852,981.23	450,852,981.23
51101	Өмч: - төрийн	450,852,981.23	450,852,981.23
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	182,222,929.70	155,415,997.13
51210	Өмнөх үеийн үр дүн	182,222,929.70	182,222,929.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-26,806,932.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	731,405,315.28	731,405,315.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,364,481,226.21</b>	<b>1,337,674,293.64</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>953,275,373.14</b>	<b>998,576,301.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>112,921,561.14</b>	<b>101,296,901.25</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	112,921,561.14	101,296,901.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,708,513.31	61,909,537.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,541,070.00	10,324,450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,347.31	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,163,096.00	51,585,087.35
120009	Бусад орлого	89,213,047.83	39,387,363.90
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>840,353,812.00</b>	<b>897,279,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	765,186,200.00	891,172,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	765,186,200.00	891,172,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35,667,612.00	6,106,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,667,612.00	2,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,766,900.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	39,500,000.00	00.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	39,500,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>875,231,783.39</b>	<b>1,025,383,233.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>875,231,783.39</b>	<b>1,025,383,233.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	872,862,328.02	1,023,572,795.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	648,962,205.00	751,277,934.96
210101	Үндсэн цалин	608,619,344.00	751,277,934.96
210102	Нэмэгдэл	40,342,861.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,335,542.87	16,789,272.02
210201	Тэтгэврийн даатгал	1,138,362.90	1,525,638.15
210202	Тэтгэмжийн даатгал	142,294.90	272,604.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	113,835.58	145,472.00
210204	Ажилгүйдлийн даатгал	24,042.40	30,949.89
210205	Эрүүл мэндийн даатгал	12,917,007.09	14,814,607.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,295,311.09	48,030,136.01
210301	Гэрэл, цахилгаан	10,903,993.81	9,802,032.02
210302	Түлш, халаалт	29,856,018.08	33,610,503.99
210303	Цэвэр, бохир ус	7,366,899.20	4,617,600.00
210304	Байрны түрээс	3,168,400.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	46,350,734.02	43,545,365.02
210401	Бичиг хэрэг	4,831,187.52	6,087,932.26

210402	Тээвэр, шатахуун	36,697,387.00	31,689,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,675,129.50	4,261,932.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,147,030.00	1,266,160.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17,246,544.00</b>	<b>13,365,067.10</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	76,400.00	325,543.10
210502	Хоол, хүнс	16,872,094.00	13,005,524.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	298,050.00	34,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,896,127.50</b>	<b>39,831,582.20</b>
210604	Урсгал засвар	18,896,127.50	39,831,582.20
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,444,960.00</b>	<b>6,410,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,444,960.00	6,410,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>450,000.00</b>	<b>1,233,262.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	533,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	450,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	80,000.00
210807	Газрын төлбөр	00.00	126,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	43,712.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>68,880,903.54</b>	<b>103,089,575.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,310,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	375,000.00	535,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,505,903.54	98,244,575.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,369,455.37</b>	<b>1,810,438.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,325,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,325,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,369,455.37</b>	<b>485,438.82</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,369,455.37	485,438.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>78,043,589.75</u></b>	<b><u>-26,806,932.57</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,108,333.10</b>	<b>00.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,108,333.10	00.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>21,794,743.43</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,403,013.32	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	16,391,730.11	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-19,686,410.33</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>58,357,179.42</u></b>	<b><u>-26,806,932.57</u></b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>817,394,882.00</b>	<b>907,668,850.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>16,541,070.00</b>	<b>10,389,450.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	16,541,070.00	10,389,450.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	16,541,070.00	10,389,450.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,541,070.00	10,324,450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	65,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>800,853,812.00</b>	<b>897,279,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	765,186,200.00	891,172,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	765,186,200.00	891,172,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35,667,612.00	6,106,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,667,612.00	2,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,766,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>807,453,757.00</b>	<b>907,668,850.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>807,453,757.00</b>	<b>907,668,850.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>805,084,301.63</b>	<b>905,858,411.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	647,265,356.82	753,562,534.41
210101	Үндсэн цалин	404,907,588.00	479,454,735.00
210102	Нэмэгдэл	242,357,768.82	274,107,799.41
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,178,558.44	16,213,230.01
210201	Тэтгэврийн даатгал	2,162,702.00	81,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	9,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	7,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	2,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,015,856.44	16,112,230.01
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,334,311.09	47,801,034.01
210301	Гэрэл, цахилгаан	9,103,993.81	9,572,930.02
210302	Түлш, халаалт	24,653,018.08	33,610,503.99
210303	Цэвэр, бохир ус	6,408,899.20	4,617,600.00
210304	Байрны түрээс	3,168,400.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	44,866,678.28	40,167,732.75
210401	Бичиг хэрэг	5,033,076.78	4,687,900.00
210402	Тээвэр, шатахуун	32,223,800.00	28,762,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,984,129.50	4,411,932.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,625,672.00	2,065,499.99
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,410,822.00	13,510,380.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	450,000.00	149,950.00
210502	Хоол, хүнс	13,960,822.00	12,721,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	638,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,283,615.00	23,942,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	3,065,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	33,283,615.00	19,877,350.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,444,960.00	6,410,600.00

210702	Дотоод албан томилолт	6,444,960.00	6,410,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	450,000.00	3,390,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,733,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	450,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	80,000.00
210807	Газрын төлбөр	00.00	126,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	850,000.00	860,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	850,000.00	860,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,369,455.37</b>	<b>1,810,438.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	1,325,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,325,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,369,455.37	485,438.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,369,455.37	485,438.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>9,941,125.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>9,941,125.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,941,125.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	9,941,125.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,941,125.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-9,941,125.00</u></b>	<b><u>00.00</u></b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	303,726,981.23	425,919,301.00	123,865,750.28	853,512,032.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>303,726,981.23</b>	<b>425,919,301.00</b>	<b>123,865,750.28</b>	<b>853,512,032.51</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	147,126,000.00	00.00	58,357,179.42	205,483,179.42
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>450,852,981.23</b>	<b>731,405,315.28</b>	<b>182,222,929.70</b>	<b>1,364,481,226.21</b>
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>450,852,981.23</b>	<b>731,405,315.28</b>	<b>182,222,929.70</b>	<b>1,364,481,226.21</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>450,852,981.23</b>	<b>731,405,315.28</b>	<b>182,222,929.70</b>	<b>1,364,481,226.21</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-26,806,932.57	-26,806,932.57
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>450,852,981.23</b>	<b>731,405,315.28</b>	<b>155,415,997.13</b>	<b>1,337,674,293.64</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	901,472,500.00	901,076,511.18	395,988.82	99.96
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	901,472,500.00	901,076,511.18	395,988.82	99.96
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	900,142,500.00	899,751,511.18	390,988.82	99.96
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	753,562,600.00	753,562,534.41	65.59	100.00
210101	Үндсэн цалин	479,454,800.00	479,454,735.00	65.00	100.00
210102	Нэмэгдэл	274,107,800.00	274,107,799.41	0.59	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,598,100.00	16,213,230.01	384,869.99	97.68
210201	Тэтгэврийн даатгал	88,700.00	81,400.00	7,300.00	91.77
210202	Тэтгэмжийн даатгал	10,400.00	9,900.00	500.00	95.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,300.00	7,700.00	600.00	92.77
210204	Ажилгүйдлийн даатгал	2,100.00	2,000.00	100.00	95.24
210205	Эрүүл мэндийн даатгал	16,488,600.00	16,112,230.01	376,369.99	97.72
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,802,500.00	47,801,034.01	1,465.99	100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,573,000.00	9,572,930.02	69.98	100.00
210302	Түлш, халаалт	33,611,900.00	33,610,503.99	1,396.01	100.00
210303	Цэвэр, бохир ус	4,617,600.00	4,617,600.00	-	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	39,866,600.00	39,862,232.75	4,367.25	99.99
210401	Бичиг хэрэг	4,688,000.00	4,687,900.00	100.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	28,723,800.00	28,722,400.00	1,400.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,414,800.00	4,411,932.76	2,867.24	99.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,799,999.99	0.01	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	13,371,100.00	13,370,880.00	220.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	149,950.00	50.00	99.97
210502	Хоол, хүнс	12,617,800.00	12,582,430.00	35,370.00	99.72
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	603,300.00	638,500.00	(35,200.00)	105.83
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,132,800.00	21,132,800.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,065,000.00	3,065,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	17,067,800.00	17,067,800.00	-	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	6,291,800.00	6,291,800.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	6,291,800.00	6,291,800.00	-	100.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	656,500.00	656,500.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	450,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	80,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	126,500.00	126,500.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	860,500.00	860,500.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	860,500.00	860,500.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1330000.00	1325000.00	5,000.00	99.62
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,330,000.00	1,325,000.00	5,000.00	99.62
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,330,000.00	1,325,000.00	5,000.00	99.62
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	901,472,500.00	901,076,511.18	395,988.82	99.96
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	891,172,500.00	890,687,061.18	485,438.82	99.95
131001	Улсын төсвөөс санхүүжих	891,172,500.00	890,687,061.18	485,438.82	99.95
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10,300,000.00	10,389,450.00	(89,450.00)	100.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,300,000.00	10,324,450.00	(24,450.00)	100.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	65,000.00	(65,000.00)	0.00

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>6,106,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>6,106,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	6,106,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	305,500.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	265,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	0.00	139,500.00
210502	Хоол, хүнс	0.00	139,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	2,809,550.00
210604	Урсгал засвар	0.00	2,809,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	118,800.00
210702	Дотоод албан томилолт	0.00	118,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	2,733,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,733,550.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	6106900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	6,106,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3,766,900.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		